



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 02 дугаар сарын 08

№ 01/09 АУА-2018/13/СТА-ТШЗ Мандалговь хот

Төлбөр барагдуулах тухай

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Сайхан-овоо сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 89,068,697.00 /Наян есөн сая жаран найман мянга зургаан зуун ерэн долоон/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Эвлэрлийн гэрээ хийсэн 7 иргэний 41,587,375.00 /Дөчин нэгэн сая таван зуун наян долоон мянга гурван зуун далан таван/ төгрөгийн зээлийн үлдэгдлийг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

Энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74<sup>1</sup>.8.-д /Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж энэ хуулийн 75 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. Энэ захирамжийг талууд сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэг адил албадан гүйцэтгэнэ./, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.-д /Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүрэг үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй./ гэж заасныг тус тус зөрчсөн.

1. Төсөл хэрэгжүүлэгч 22 иргэн гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөлгүй хугацаа хэтрүүлснээс нийт 47,481,322.00 / дөчин долоон сая дөрвөн зуун наян нэгэн мянга гурван зуун хорин хоёр / төгрөгийн авлагыг зээлдэгч нар төлөөгүй зөрчил илэрсэн.


Энэ нь Иргэний тухай хуулийн 222 дугаар зүйлийн 222.4.-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна/, 222.5.-т /Мөнгөн төлбөрийн үүрэг хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй./, зээлдүүлэгчтэй байгуулсан “Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээ”-ний 2.2-т /Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж, дуусгана. /Хавсралт-1// гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн

2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.7-д /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эвлэрлийн гэрээ хийсний дагуу төлбөрөө төлөөгүй иргэдийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлж, зээлийн үлдэгдлийг бүрэн барагдуулах;
2. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн нийт **89,068,697.00** /Наян есөн сая жаран найман мянга зургаан зуун ерэн долоон/ төгрөгийн зээлийн авлагыг нэр бүхий 29 зээлдэгч /Хавсралт 1/ нараар нөхөн төлүүлж, Сайхан-Овоо сумын Сум хөгжүүлэх сангийн Төрийн сан банк дахь 100081255406 дугаар дансанд 2018 оны 5 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх.

Актыг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулах арга хэмжээ авах, биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Сайхан-овоо сумын Засаг дарга Б.Түвшинбаатар, нягтлан бодогч З.Цэдэнрулам, сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн Р.Оюунтуяа нарт хариуцуулав.

**ТОГТООСОН<sup>1</sup>:**  
АУДИТОР  Д.ДОЛЖИНСҮРЭН



**АКТЫГ**

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ЗАСАГ ДАРГА  Б.ТҮВШИНБААТАР  
НЯГТЛАН БОДОГЧ  З.ЦЭДЭНРУЛАМ



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.